

БУДДЫН ФИЛОСОФИД ЭРХЭТ ТЭНГЭРИЙГ НЯЦААДАГ НЬ

Г.Лувсанцэрэн, МУИС, НШУС, Шашин судлалын тэнхим Академич.

Түлхүүр үг : эрхэт үйлдэгч, Ертөнцийн эзэн, хоосон чанар, үнэмлэхүй, янагуухуй, би-д баримтлахуй, би үгүй: бодгалийн би үгүй, номын би үгүй

Эдүгээ манайд бурханы шашныг буддын бус, загалмайтны ёсны үндэстэй сэтгэхүйгээр ухаарч, хамгийг бүтээгч, бүхнийг чадагч бурхан тэнгэр байдаг тухай ярьдаг, түүнээс аврал өршөөл, тус дэмжлэг хүсэж гуйдаг. Гэтэл Буддын сургаал, түүний онолын сэтгэхүйд бүхнийг бүтээгч, чадагч "ид шидтэн" байдаг хэмээх үзлийг үгүйсгэдэг юм.

Буддын шашин үзэхдээ: бурханы мөн чанар хүний мөн чанарт бий, хүн бүхэн бурхан болох боломж, чадавхийг өөртөө агуулна гэдэг. Үнэндээ хүнийг л бурхан болгох, тэр бурханлаг чанарт нь хүргэхийг буддизм зорьж байгаа болохоор хүнээс өөр хэн бурхан болох билээ. "Тонилохуйн чимэг" хэмээх монгол сударт тодорхойлохдоо: "Бурханы зүрхэн хамаг амьтнаа буй болъюу . . . хамаг амьтнаа бурханы зүрхэн гурван зүйлээр буй. Тэр гурван аль буй хэмээвээс бурханы бие түгээмэл, мөн чанараа ялгал үгүй, язгуур буй хийгээд буюу. Бурханы бие түгээмэл хэмээх нь бурхан номын биет буюу. Номын бие хэмээвээс хоосон болой. Тэр хоосон бээр амьтан бүгдэд түгээмлийн тул амьтан бурханы зүрхэт буй" гэсэн байдаг.

Ийнхүү бурханы бие түгээмэл гэдэг нь бүгдэд байгаа түгээмэл чанар, хоосон чанар юм. Бурханы зүрхэн мөн чанартаа ялгалгүй гэсэн нь бурханы мөн чанар амьтны мөн чанар хоёрт сайн муу, их бага, өндөр нам гэхийн ялгал үгүй, адил юм гэсэн үг. Ингээд хамаг амьтанд бурханы язгуур буй гэдэг. Тэгэхдээ таван зүйлээр буй, өөрөөр хэлбэл таван зэрэгтэй гээд, түүнийг дэс дараалан хөгжүүлж, жинхэнэ бодь сэтгэлтэн болж, билгийн чанадад хүрснээр бурханы хутгийг олж чадна, нирванд хүрнэ гэж буддизм сургадаг. Монголын буддизмын энэхүү гүн утгаар бол, хүн гагцхүү оюунаа боловсруулан чөлөөлж, сэтгэлээ аливаа алгасралаас салган барьж, ариусган төгөлдөржүүлснээр бие, хэл, сэтгэлийн дээд амарлингуй, энэрэнгүй ариун чанарт хүрнэ, өөрийнхөө бурханлаг чанарт хүрнэ. Чухам ингэж өөрийгөө хөгжүүлэх, дотоод боломжоо ашиглахад нь хүнд туслах, чиглүүлэхийг л бурханы шашин зоридог билээ.

Иймээс ч эртний Энэтхэгийн буддын их сэтгэгч Нагаржуна бүхнийг бүтээн чадагч Вишну тэнгэр байдаг тухай санааг шүүмжилж, ертөнцийг бүтээгчийн тухай үндэслэлийг няцаахад тусгайлан зориулж "Эрхэт үйлдэгчийг арилгах хийгээд Вишну үйлдэгч гагцыг арилган үйлдэгч" (санскритаар: *Isvara kartṛtva nirākṛti Viṣṇor eka kartṛtva nirākaraṇa nāma*, төвдөөр: *dBang phyug byed pa po nyid sel ba dang khyab 'jug byed pa po gcig nyid sal bar byed pa zhes bya ba*)¹ гэдэг зохиолыг бичжээ. Үүнд Нагаржуна өөрийн үндэслэсэн төв үзлийн онолын үүднээс асуудлыг авч

¹ Эрхэт үйлдэгчийг арилгах хийгээд Вишну үйлдэгч гагцыг арилган үйлдэгч, - Монгол Данжуур, 221 дүгээр боть, 623 - 626 дахь хуудас.

үзээд, "бүтээгчийн" бүтээлийг бүтсэнийг бүтээсэн, бүтээгүйг бүтээсэн хоёрын алин болох талаас, мөн бүтээгчийг бүтээхийн байх байхгүй, бүтээгч бүтээл хоёр хийгээд бүтээгчийн өөрийн төрсөн, эс төрсөн, өөр ба бусад гэсэн талуудаас нь нягтлан шинжлээд, ертөнцийг бүтээгчийн тухай үзлийг учир шалтгааны үндэслэлтэйгээр, бодролоор няцаасан байна.

Бүтээхийг байх байхгүйн талаас юуны өмнө авч үзээд, бүтсэнийг бүтээв үү, бүтээгүйг бүтээв үү гэсэн асуудлыг тавьж, бүтсэнийг бүтээнэ гэвэл, нэгэнт бүтсэн учир хэрхэн бүтээх, бүтээгүйг бүтээнэ гэвэл, "элсэнд гүнжидийн тос эс бүтсэн хийгээд яст мэлхийн үс тэргүүтэн эс бүтсэн"-чилэн түүнийг хэрхэн бүтээх вэ (хамгийг бүтээгч юм бол түүнийг бүтээчих гэсэн утгаар) хэмээн өгүүлсэн байна. Хэрэв бүтсэн, бүтээгүй хоёулаа гэх юм бол эсрэг тэсрэг харшлах учир гэгээ харанхуй, амьдрах үхэх хоёулаа нэгэн зэрэг байхын аргагүйтай адил юм гэж янагуухийн томьёоны утганд нь авч үзжээ. Харин вум танжурвын ёсоор үнэмлэхүй утгаар нь авч үзэх юм бол, бүтсэн, бүтээгүй хоёулаа үнэхээр бус, түүнийг шүтэлцүүлсэн дээд утга л боломжтой бөгөөд харин энэхүү үнэмлэхүй дээд утгыг бүтээгч гэж яахин байж чадах билээ.

Зохиогч улмаар үйлдэгч өөрөө бүтэж байж бүтээв үү, бүтээгүйгээр бүтээв үү гэсэн асуулт тавиад, өөрөө төрөөгүйгээр бусдыг бүтээнэ гэж байхгүй, хүүсэр эмийн хүү эс төрсөн тул газар малтах тэргүүтнийг яаж хийх билээ, Үйлдэгч (Вишну тэнгэр) үүн лүгээ яг нэгэн адил гэж үзсэн. Хэрэв бүтээгч төрөөд бүтээсэн гэвэл, Бүтээгч тэр өөрөө хэрхэн төрөх (бүтэх) вэ, өөрөөс төрөх үү, бусдаас төрөх үү гэж бүтээгчийг өөр хийгээд бусдын ухагдахуунаар шинжилж үзээд, өөрөө төрөөгүй байж, өөрийн мөн чанараас төрнө гэж хэрхэн байх билээ, асар хурц илдний ир ч өөрийн биеийг огтолж чадахгүй, бүжигчин хичнээн мэргэжсэн ч өөрийн мөрийг хөлөглөн бүжиж чадахгүй гэж жишээлсэн байна. Ийнхүү өөрөө бүтээгүй байж өрөөл бусдыг хэрхэн бүтээж чадах билээ. Бусдаас төрнө гэвэл, өөрөө төрөөгүй байж, түүний бусад гэж юу байх билээ хэмээжээ. Өөр бусад хоёулаас төрсөн гэвэл, өөрөө үүсгэгдэхүүн хийгээд өөрөө үүсгэгч байж чадахгүй гээд, түүнийг өөрөө эцэг байхын зэрэг хүү байх (өөрийн эцэг болон өөрийн хүү нэгэн зэрэг болох) учрал ертөнцийн ёсонд ч дуулдсангүй гэжээ. Хэрэв бусдаас гарахыг үндэслэж болно гэвэл, тэр нь мухардах хязгаар үгүй үргэлжилнэ, ертөнцөд эх эцэс гэж үгүйн тул гэж үндэслэсэн байна. Иймээс үйлдэгч бүтээгүй, эс бүтсэн тул бүтээгч бус гэж дүгнэжээ. Бүтээгч хийгээд бүтээлийн үнэн чанарыг бодролоор нягтлан эрээд үзэхэд үнэхээр бүтсэн, бие даасан чанарууд үл олдох бөгөөд тэдгээр нь гагцхүү харьцангуй шүтэлцсэн харилцааг томьёолсон ертөнцийн томьёо, нэрийтгэл төдий ажээ.

Ийнхүү бүхнийг бүтээн чадагч үндэс болсон чанагуухи далд Ертөнцийн эзэн байхгүй гэж нотолж буй болохоор буддын философид ертөнцийн тайлбарлалыг бидний нүднээ тусан буй янагуухийн юмсаар хязгаарладаг юм уу гэсэн асуулт гарч болох юм. Гэтэл огт тийм биш ээ.

Буддын философийн эцсийн зорилго бол бодгалийг (хүнийг) ертөнцийн хүлээсээс ангижруулах, тонилохуйн үнэн мөрийг олон зааж, хүний өөрийн жинхэнэ дотоод чанарт хүргэхүй болохыг бид дурдсан. Иймээс ертөнц, түүний аливаа юмсыг бүхэлд нь үнэхээрийн чанартай бус хэмээн үзэж, ухаарагчийн эндүүрлийн үзэгдэлд барьж тайлбарлана. Янагуухийн юмсыг хааж, би-үүйд барьж үзсэнээр үнэн чанарыг ухаарч, тонилохуйн мөрд орно гэж ойлгодог билээ. Нагаржуна бичихдээ: "Түүнчилэн

ирсэн бээр ертөнц дахины номын ёсыг үл эвдээд үнэмлэхүүд хэзээ бээр ном үзүүлсэн үгүй хэмээн номлосон хиргүй өгүүлэл үүнийг үл оносноор түүнээс аймуй"¹ хэмээн ертөнцийн янагуухийг "эвдэх" буюу түүнийг томьёо, нэрийтгэлийн төдий хуурмаг хэмээн үзэж давалгүйгээр үнэмлэхүйг илэрхийлэх боломжгүй гэсэн байна.

Ийнхүү буддизмын онолд ертөнцийг уг язгуураар нь тусган авч, биднийг хүрээлэн буй янагуухийн юмсыг тургуурлах бус, харин бүхний үндэс язгуур болсон үнэмлэхүй чанагуухи чанарыг гол тулгуураа болгон юмсыг тайлбарлаж, сургаалаа номлодог. Үүнийг буддын философи сэтгэхүйн хөгжлийн өндөрлөг болсон хэтрүүлэгч төв үзэлтний (санскритаар: madhyamaka prāsangika, төвдөөр: dbu ma thal 'gyur pa - вум танжурва) ухаарлаар товч авч үзье.

Нагаржуна болон түүний шавь нар: бүхний үндэс язгуур нь хоосон чанар (śūnyatā) гэж үзсэн бөгөөд хоосон чанар хэмээгч ямар ухагдахуун болох талаар бид янз бүрийн төвшинд өгүүлж байсан билээ. Давтан хэлэхэд, хоосон чанар нь нэгэнт бүхний үндэс болох учраас хүртэн мэдэж болох аливаа тодорхой шинж үгүй, барин тавин байх тодорхой харилцаанаас чанад гарсан байж таарна. Үнэндээ бүхний үндэс болж байгаа зүйл нь хамгийн микро жижиг ч гэлээ биетийн үл хуваагдах хэсэг байж чадахгүй. Түүнийг эрээд олохгүй, тэр чинь өөрөө биет болчихоос биш, биет бүхний үндэс болж чадахгүй. Чингэхэд хүрвэл, ертөнц дотогшоо хязгаартай болчихно. 2000 шахам жилийн өмнө бясалгах сэтгэхүйн хүчээр олсон төв үзлийн ёсны энэ ухаарлыг шинжлэх ухаан XX зууны үед л сая баримтаар нотолсныг бид мэднэ.

Цаашилбал, хоосон чанарыг билиг барамидын болон төв үзлийн ном сударт 16, 18, 20 хоосон чанар гэх зэргээр ангилан нэрлэж, тайлбарлаж байсан билээ. Энэ бол хоосон чанарыг дотор нь хувааж ангилсан хэрэг биш, харин түүнийг олон талаас нь авч үзэж, тодотгон дэлгэрүүлсэн хэрэг, хоосон чанарын тал, аспектүүд юм. Монголын нэрт сэтгэгч, философич Агваанбалдан бичихдээ: "дотоод хоосон чанар тэргүүтэн арван зургаан хоосон чанар, бодотын хоосон чанар тэргүүтэн дөрвөн хоосон чанар нь дээд утгын (үнэмлэхүй – Г.Л.) үнэний ялгал"² болно гэсэн байдаг.

Хоосон чанар, үнэмлэхүй, нирван гэдэг бол нэг л эрэмбийн ойлголтууд юм. Тэдгээр нь чухам аль талаас, ямар харьцаанд авч үзэж байгаагаараа л ялгагдана.

Ийнхүү үнэмлэхүй чанарыг хорин хоосон чанараар, хураавал хоёр би үгүйгээр илэрхийлнэ гэж Их Хөлгөний сургаалд үздэг. Буддын философичдын авч үзэж байгаа Би нь аливаа бүхний өөрийн эзэн чанар болно. Би-г номын би (юмсын би), бодгалийн би (ухамсарлагч бие хүний би) гэж хоёр ангилна.

Эл хоёр би үгүй: бодгалийн би үгүй, номын би үгүйн тухай товч өгүүлж, түүгээр үнэмлэхүй чанар хэрхэн илэрхийлэгдэж байгааг авч үзье.

Бага хөлгөний философийн урсгалууд, тухайлбал өвөрмөц өгүүлэгчид (вайбхашика чиглэлийнхэн) юмсын болон бодгалийн би-г юуны өмнө цогцтой холбон үзнэ. Үүнд таван цогцын аль нэг юм уу, цогцын чуулганыг

¹ Монгол Данжуур, 105 дугаар боть, 396 дэх хуудас.

² Агваанбалдан, Дөрвөн тогтсон тааллын хоёр үнэний ялгал. Төвд бар, 746 дэх хуудас.

(тавуул нийлснийг) би-д барина. Судартны чиглэлийн сэтгэгчид сэтгэлийн үргэлжлэлийг бодгаль гэнэ. Их хөлгөний йогачара сэтгэгчид хотлын шүтээнийг (бүхний суурь сэтгэлийг) бодгалийн би гэж үзнэ. Төв үзлийн өөрийн үндэстийн чиглэлийнхэн (madhyamaka svāntantrika) сэтгэлийн тийн мэдэхүйг (мэдэхүй ухамсрыг) бодгальд барьдаг байна.

Ийнхүү вайбхашикуудаас эхлэн сватантрика хүртэлх бүх сэтгэгчид бодгалийн уг чанар, би-г нэрийтгэл гээд, тэгэхдээ нэрийтгэлд бүтсэн, тухайлахад цогц юм уу, цогцын чуулганд, эсвэл түүнээс өөр утгын аль нэгэнд бүтсэн, тэдгээрээс эрэхэд би буюу юмсын болон бодгалийн эзэн чанар олдох ёстой хэмээн үздэг.

Бодгалийг ингэж үнэхээр бүтсэн гэж үзэх, түүнээс улбаалаад минийх хэмээн баримтлахыг басхүү бүдүүн нарийн хоёрт оноон барина. Буддын сургаалд би, минийх хэмээн баримтлахыг хааж, өөрийн би-г даван туулж, амарлихуйг гол зорилт болгодог учир бодгалийн би үгүйн тухай асуудал буддын сэтгэлгээний нэн чухал судлагдахуун болно. Бодгалийг хааж үзсэн бодгалийн би үгүйг басхүү бүдүүн, нарийн хоёроор ялган үзнэ. Ингэж ялгах нь буддын тогтсон таалал аль алинд адил болой.

Бага хөлгөн, тухайлбал, өөрмөц өгүүлэгчид үзэхдээ: бодгалийг мөнх ганц өөрийн эрх төгөлдөр би-д бүтсэн гэхийг бодгалийн би-д баримталсан бүдүүн гэнэ. Энэ нь өөрийн эрхээр мөнхөд өөрөө байх бодгалийн нэр. Бодгалийг өөрөө дан байн чадах эдтэйд бүтсэн гэхийг бодгалийн би-д баримталсан нарийн гэнэ. Энэ нь бодгаль өөрөө бие даан байж, аливааг үйлдэн чадахын нэр юм. Чингэхдээ цогцоос тусгаар утгатай би-г хаагаад, бодгалийг нэрийтгэлд үзэж, түүнийг даван туулсныг би үгүйд барих бөгөөд энэ нь тонилохуйн мөртэй холбогдоно.

Хэтрүүлэгч төв үзэлтнээс дорогши тогтсон таалалд бодгаль мөнх ганц өөрийн эрх төгөлдрөөс хоосныг бодгалийн би үгүй бүдүүн, бодгаль өөрөө дан байн чадах эдтэйгээс хоосныг бодгалийн би үгүй нарийн гэж үздэг.

Төв үзэл, ялангуяа хэтрүүлэгчийн тааллын үзэх нь үүнээс эрс өөр юм. Хэтрүүлэгч төв үзэлтнүүдийн тааллаар бол, аливаа нэр зүүсэн өгүүлэгдэхүүний утга нь аль нэгэн цогц, цогцын чуулган, сэтгэл, тийн мэдэхүй, түүнээс тусгаар утга эдгээрийн алинаас ч эрэхэд үл олдох бөгөөд тэсэж бүтсэн юм үгүй, иймийн тул юмс хийгээд бодгаль өөрийн бэлгэ чанараар үнэхээр бүтсэн бус, хоосон чанартай юм.

Төв үзэлтнүүд юмс оюунд бууснаар зогсохгүй, мөн уг юм, ахуй ёс өөрөө үнэхээр бүтээгүй хэмээн үзэх бөгөөд тэр нь хаагдахууныг хаасан, би-г хааж, би үгүйг барьж ухаарсан хэрэг болно.

Мадхьямака онолоор бол, мөнх ганц өөрийн эрхэт гэж байхгүй, мөнхөд оршиж бүхнийг бүтээгч байхгүй. Иймд мөнх ганц өөрийн эрхэтийн тухай энд яригдах зүйл үгүй юм. Харин янагуухийн томьёололд бол бие даан бодтой оршино гэсэн ухаарал байдаг, иймд бодгалийг өөрөө дан байн чадах эдтэйд бүтсэн гэхийг бодгалийн би-д баримталсан бүдүүн, бодгаль өөрийн чанараар үнэхээр бүтсэн гэхийг бодгалийн би-д баримталсан нарийн гэж үзнэ. Гэтэл бодгаль үнэхээрт ингэж бүтсэн нь үгүй, тэр бээр хоосон чанартай учир түүнийг би үгүй гэж, түүгээр өөрийн би-г давах, минийх хэмээн баримтлахыг даван гэтлэхийг дээд зорилтоо болгодог. Үүнд бодгаль өөрөө дан байн чадах эдтэйд бүтсэнээс хоосныг бодгалийн би үгүй

бүдүүн (макро би үгүй), бодгаль мөн чанараар бүтсэнээс хоосныг бодгалийн би үгүй нарийн (микро би үгүй) гэж вум танжурвын ёсонд үзнэ.

Харин номын би үгүйн тухай асуудлыг Бага хөлгөний философийн чиглэлүүдэд авч үздэггүй билээ. Учир нь тэдний үзлээр бол, аливаа ном буюу юмс өөрийн бэлгэ чанараар, тус үйлдэн чадах эдтэй бүтнэ гэж үзэх бөгөөд юм цогцлохын суурь нь хувиаргүй нарийн тоос (үл хуваагдах эцсийн микро бөөм байнагэсн атомлиг үзэл), үргэлжлэлийн суурь нь хувиаргүй богино агшин байна, шинжлэлийн эцэст түүнийг олох ёстой гэдэг. Ийнхүү гадаад утга, юмсыг бодтой, үнэхээр бүтсэн хэмээн үзэх учир номын би үгүйн тухай ойлголт үгүй юм.

Их хөлгөн, тухайлбал мадхьямака прасангика ёсонд номын би үгүй бүдүүн, нарийнийг авч үзнэ. Хэтрүүлэгчийн тааллаар бол, ном (юмс) үнэхээр бүтээгүй, хамгийн жижиг хувиаргүй нарийн тоос гэж байхгүй, хувиаргүй эцсийн агшин ч гэж байхгүй, түүнийг эрээд олохгүй гэдэг нь нарийн ухаарал мөн бөгөөд орчин үеийн шинжлэх ухааны мэдлэгтэй л дүйнэ. Хувиаргүй нарийн тоос хурж юмс бүтнэ гэж үзэх үзлийг номын би-д баримталсан бүдүүн гэх ба хувиаргүй нарийн тоос хурсан юмс хийгээд түүнийг баримталсан шалгадаг мэдэл өөрийн утгаас хоосныг номын би үгүй бүдүүн гэж үзнэ. Энэ нь юмсын хоосон чанарыг хэлж байгаа хэрэг. Нөгөө талаар, буддын сургаалд юмсыг томьёо нэрийтгэлийн утгатай гээд, нэрийтгэлийн суурь нь цогц хэмээн тайлбарлагдгийг бид дурдсан. Эл нэрийтгэлийн суурь үнэнээр бүтсэн гэж үзэхийг номын би-д баримталсан нарийн гэж вум танжурвын ёсонд үздэгээрээ онцлог юм. Уг сургаалын үүднээс бол тэрхүү нэрийтгэл ч үнэхээр бүтсэн бус тул нэрийтгэлийн суурь цогц үнэнээс хоосныг номын би үгүй нарийн гэнэ. Өөрөөр хэлбэл, юмсыг бид томьёо нэрийтгэлийн төдий л үнэн буй гэж баримтлах нь ч басхүү үнэхээрийн бус, янагуухийн юмс хоосон чанартай юм.

Энэхүү бодгалийн би үгүй нарийн, номын би үгүй нарийн хоёр нь хоосон чанарын суурийн үүднээс л ялгаатай, өөрөөр хэлбэл нэг нь бодгалийг үнэхээр бүтсэн бус хэмээн хаасан, нөгөө нь дүрс тэргүүтэн аливаа юмс үнэхээр бүтсэн бус хэмээн хаасан, чухам үүгээрээ ялгагдахаас бус, хаагдахууны үүднээс бол ялгаагүй юм. Чингэхлээр, бодгалийн би үгүй нарийн, номын би үгүй нарийн хоёрт нарийн бүдүүний ялгал үгүй.

Тийнхүү нэг талаас, бодгаль нь аливаа нисванис, хорт сэтгэл бүхнийг арилган давж, сэтгэлээ хөгжүүлэн ариусгаснаар их амарлингуйд хүрч гэгээрэх, нөгөө талаас, ертөнцийг уг язгуураар нь ухаарч, хоосон чанарыг танин барих ажээ. Нэг талаар ертөнцийн үнэмлэхүй чанад чанарт оюунаар хүрч (номын би үгүй нарийнийг барьж), нөгөө талаар бодгалийн билгийн чанад хязгаар буюу билгийн жинхэнэ байдалд хүрч (бодгалийн би үгүй нарийнийг барьж), нэг цэг дээр давхцан нийлж очиход аливаа ялгаа арилсан тэгш дээд чанарт хүрнэ. Үүнийг хэтрүүлэгч төв үзэлд ахуй ёсны туйл гэдэг. Ингэж бурханы хутгийг олж гэгээрэх буюу бурханлаг чанартаа хүрэх ажгуу.

Шинэ үеийн шинжлэх ухааны философийн гарамгай төлөөлөгч гэж үнэлэгддэг, германы их философич Иммануил Кантаас Эрхэт тэнгэрийн л (God) хүрч таних зүйл, "битүү юм" хэмээн орхиж байсан чанагуухи чанарт ийнхүү сэтгэлийн их ариусал, оюуны гүн бясалгалын хүчээр хүрэх нь ээ. Ертөнцийг бүтээгч Эзэн, Эрхэт тэнгэр биш, хүн хүрэх нь ээ.

Нагаржуна тэргүүтэн гарамгай сэтгэгч мэргэд хүрч байсан ажгуу. Тэдний дотор монгол мэргэд ч цөөнгүй.

Дүгнэн үзвээс, ертөнцийн язгуурт Эзэн тэнгэр, Эрхэт бүтээгчийн хийх зүйл ч үгүй, байр зай ч үгүй ажээ. Тэнд хоосон чанар буюу шүтэн барилдахуй харьцангуй харилцаа л харьцангуй оршино. Эдүгээ шинжлэх ухаан түүнд дөхөж, онолын физикчид их нэгдлийн тухай ярьж байна.

Жич: Нагаржунагийн "Эрхэт үйлдэгчийг арилган үйлдэгч" зохиоллыг Монгол Данжуурт санскрит, монгол хоёр хэлээр бичсэн байдаг бөгөөд бид энд монгол эхийг хавсаргав.